

**“БНХАУ ДАХЬ ШИНЭТГЭЛ, НЭЭЛТТЭЙ БОДЛОГЫН
ГҮНЗГИЙРЭЛТ: МОНГОЛ-ХЯТАДЫН ХАРИЛЦААГ
ХӨГЖҮҮЛЭХ ШИНЭ БОЛОМЖ”
СЭДЭВТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ
БАГА ХУРАЛ БОЛЛОО**

ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам “БНХАУ дахь шинэтгэл, нээлттэй бодлогын гүнзгийрэлт: Монгол-Хятадын харилцааг хөгжүүлэх шинэ боломж” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг 2013 оны 12-р сарын 24-ний өдрийн Мягмар гаригийн үдээс өмнө 09.00-12.30 цагийн хооронд “Кемпински Хаан Палас” зочид буудлын “Алтай” танхимд зохион явуулж байна.

Монгол-Хятадын харилцаанд нөлөө үзүүлэхүйц чухал үйл явдлууд сүүлийн 2-3 сард боллоо. Тухайлбал, Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг 2013 оны 10-р сарын 22-26-нд БНХАУ-д айлчилж, “Монгол Улс, БНХАУ-ын хооронд стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх дунд, урт хугацааны хөтөлбөр” болон 10 гаруй хэлэлцээр, баримт бичигт гарын үсэг зурлаа. ХКН-ын Төв Хорооны 18 дахь удаагийн III бүгд хурал 2013 оны 11-р сарын 9-12-нд хуралдаж, БНХАУ-ын шинэтгэл, нээлттэй бодлогыг гүнзгийрүүлэх тухай чухал шийдвэр гаргалаа. Энэ хоёр үйл явдал Монгол, Хятад хоёр улсын төдийгүй олон улсын хэвлэл мэдээлэл, судлаач, улс төрч, эдийн засагч нарын анхаарлын төвд буй судалгааны чухал сэдэв болоод байна. Иймд хурлыг зохион байгуулагчид энэ хоёр үйл явдлын талаар мэргэжлийн судлаачид, дипломатууд, албаны хүмүүсийн үзэл бодол, байр суурийг Монголын олон нийтэд хүргэх нь зүйтэй хэмээн үзэж энэхүү эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулахаар шийдвэрлэсэн юм.

ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, БНХАУ-ын ЭСЯ хоёр бол Монгол-Хятадын харилцаа, хамтын ажиллагааг стратегийн түншлэлийн түвшинд харилцан ашигтай, тал бүрээр хөгжүүлэх, хоёр ард түмний найрамдал, харилцан ойлголцол, итгэлцлийг бэхжүүлэх тал дээр ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг. Өмнөд хөрш БНХАУ дахь шинэтгэл, нээлттэй бодлого цаашид хэрхэн гүнзгийрэхийг хөрш орнуудын нэгэн адил Монгол орон анхааралтай ажиглаж байна. Хятадын шинэ удирдлагын зүгээс гаргасан энэхүү шийдвэр нь 1978 оноос эхэлсэн шинэтгэл, нээлттэй бодлогыг хэрэгжүүлэх явцад олсон амжилтаа бататган, Хятадын нийгэмд тулгамдаж буй

асуудал, бэрхшээл, алдаа дутагдлыг засч залруулах, мөн зах зээлийн тогтолцоо руу улам эрчимтэй орох замаар Хятадын хөгжлийн тогтвортой байдлыг хангаж, шинэтгэл, нээлттэй бодлогыг улам гүнзгийрүүлэхэд чиглэж байна. Өнөөгийн үе шатны шинэтгэлийн бодлогын онцлог бол эдийн засгийн хөгжлийн загварыг нэлээд ул суурьтай өөрчилж байгаад орших бөгөөд ач холбогдол, цар хүрээгээрээ дэлхийн эдийн засагт ч шууд нөлөөлөх юм. Иймд бид хөршийнхөө эдийн засаг, улс төр, нийгмийн хүрээнд гарч буй, ойрын ирээдүйд гарах хувьсал өөрчлөлтийн талаарх мэдээлэл, ялангуяа Хятадын нэртэй эрдэмтний үзэл бодол, байр суурийг олон нийтэд хүргэхийг зорьж байна. Тус хуралд БНХАУ-ын Ардын Их Сургуулийн Хэвлэл мэдээллийн сургуулийн захирал, Нанькай Их Сургуулийн Биньхай хөгжлийн судалгааны хүрээлэнгийн захирал Жао Цижэн урилгаар оролцож, үндсэн илтгэлийг тавих юм.

Хятадын шинэтгэл, нээлттэй бодлого амжилттай үргэлжлэн гүнзгийрэх нь Монгол Улсын эдийн засгийн хөгжилд шинэ түлхэц үзүүлэх, түүний дотор уул уурхай, эрчим хүч, аж үйлдвэр, хөдөө аж ахуйн бараа бүтээгдэхүүний зах зээл өргөжин тэлэхэд таатай нөхцөл, бололцоо бүрдэнэ. Өөрөөр хэлбэл, БНХАУ-д шинэтгэл, нээлттэй бодлого гүнзгийрэхийн хирээр өмнөд хөрш улам нээлттэй, зах зээлийн тогтолцоонд шилжих үйл явц улам түргэсэх нь манай хоёр орны харилцаа, хамтын ажиллагаанд шинэ үе шат, шинэ боломж нээгдэх болно хэмээн судлаач, шинжээчид таамаглаж байна.

Эрдэм шинжилгээний хуралд Монгол, Хятадын эрдэмтэд тус бүр нэг үндсэн илтгэл тавихаас гадна Монгол Улсын Гадаад харилцааны яам, Эдийн засгийн хөгжлийн яам, Монгол Улсад хөрөнгө оруулагч БНХАУ-ын бизнесмэнүүдийн төлөөлөл, МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн багш нар болон бусад албаны хүмүүс үг хэлнэ. Тус эрдэм шинжилгээний хуралд УИХ, яам агентлагууд, эрдэм шинжилгээний хүрээлэн төвүүд, их сургууль, бизнес, хэвлэл мэдээлэл болон төрийн бус байгууллагыг төлөөлсөн 80-100 орчим хүн уригдан оролцох гэж байна.

Эрдэм шинжилгээний хурлаар хэлэлцэх сэдвийн агуулга, ач холбогдлыг авч үзсэн ч, Монгол, Хятадын нэртэй эрдэмтэд, улс төрчид, бизнесийн зэрэг олон салбарын төлөөлөл уригдан оролцох байдлаас харахад энэхүү хурал ихээхэн амжилттай бөгөөд үр дүнтэй болно гэдэгт зохион байгуулагчид итгэлтэй байна.

ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн,
БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам
2013 оны 12 дугаар сарын 24